




# 2017 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ




# 2017 ОН: ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ба ТОП-20 ИНДЕКС

## Зах зээлийн үнэлгээ

**МХБ-ийн зах зээлийн үнэлгээ оны эхнээс 12 сарын 31-нийг хүртэлх хугацаанд 67,4 хувиар өссөн**



## ТОП-20 индекс



**ТОП-20 Индекс мөн хугацаанд 68,9 хувийн өсөлттэй байна**


# НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН

МХБ нь 2017 онд **859.2 тэрбум** төгрөгийн арилжаа хийгдсэнээр түүхэн гээг амжилтаа шинэчлэн тогтоосон бөгөөд өмнөх үеүүдтэй харьцуулахад 2015 оноос 57.2%, 2016 оноос 140%-аар тус тус нэмэгдэж, угэвхижсэн.



# ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

2017 онд нийт хувьцааны арилжааны дүн **76.4 тэрбум** төгрөгт хүрч, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны илэвхи өмнөх оноос 76%-аар нэмэгджээ.






# 2017 ОНЫ IPO: АЙ-ТУУЛС ХК-ИЙН АРИЛЖАА



**“Айтүүлс” ХК нь нийт хувьцааныхаа 38.86%-ийг буюу 13.4 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон. Анхдагч зах зээлийн захиалгад 1,072 хувь хүн, аж ахуйн нэгжүүд оролцож, нийтгээ 39,786,996 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгснөөр захиалга нийлүүлэлтээсээ 3 дахин давсан.**



# АПУ ХК-ийн АРИЛЖАА




"АПУ" ХК-ийн нийт гаргасан 742,877,000 ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй "Эвэргрийн инвестмент" ХХК-ийн 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 1,064,181,553 ширхэг хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан. 2017 оны 12-р сарын 5-ны өдөр АПУ ХК-ийн хувьцааны ханш 906.8 төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээ 950 тэрбум төгрөгт хүрч, түүхэнд гээг амжилтаа шинэчлэн тогтоосон.

"АПУ" ХК-ийн зах зээлийн үнэлгээ оны эцсийн байгалаар 762 тэрбум төгрөг

# КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

2017 онд компанийн бондын нийт арилжаа **10.2 тэрбум** төгрөгт хүрсэн ба “Сүү Бонд”-ын нийт 67,547 ширхэг буюу 6,754,700,000 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах захиалга бүртгэгдсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс **13%-аар давж**, анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт эхний өдөртөө дууссан. 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрөөс Сүү ХК-ийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдэж, оны эцсийн байгалаар **4.2 тэрбум** төгрөгийн арилжаа хийгдээг байна.



# ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

2017 онд нийт **772.5 тэрбум** төгрөгийн арилжаа хийж, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд өрсөлдөөнт арилжааны хэлбэрийг дахин нэвтрүүлснээр тайлан хугацаанд 3 удаагийн арилжаагаар нийт **9.3 тэрбум** төгрөгийн үнэт цаасыг өрсөлдөөнт хэлбэрээр амжилттай арилжааллаа. ЗГҮЦ-ны өрсөлдөөнт хэлбэрийн эхний арилжаанд үнэт цаасны зарласан тоо ширхэгээс 2 дахин их буюу нийт **124,900** ширхэг худалдан авах захиалга ирж, үнэт цаасны хүүгийн түвшин **11.7%**-иас **10.3%** болж буурсан.



2015 он



2016 он

2017 он

■ (Анхдагч)

■ (Хоёрдогч)





# ГОЛЛОХ БУСАД ҮЙЛ ЯВДЛУУД

## **ҮНЭТ ЦААСНЫ ДАВХАР БҮРТГЭЛИЙН ЖУРАМ БАТЛАГДАВ.**

СЗХ-ны 2017 оны 11 сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмыг батлав.

## **“ЛЭНДМН” ХХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭВ.**

Лэндмн компани нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан олон нийтэд нийт хувьцааныхаа 12.5 хувь буюу 100 сая ширхэг, стратегийн хөрөнгө оруулагчдад 12.5 хувь буюу 100 сая ширхэг хувьцаа арилжаалж нийт 5.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

## **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ИДЭВХИЖҮҮЛЭХ, НИЙТ ОРОЛЦОГЧДЫН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ-Д ЧИГЛЭН:**


Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яамнаас Үнэт цаасны зах зээлийн сургалт явуулах эрх бүхий “Мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээ”-г авч, сургалтыг төрөлжүүлэн биржийн сургалтын танхимыг тохижуулав. Мөн хөрөнгийн зах зээлийн реалити шоу нэвтрүүлгийг Монголны үндэсний телевизтэй хамтран амжилттай зохион байгуулав.

## **ОЛОН УЛСЫН КАСТОДИАНЫ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТРЭВ.**

Олон улсын томоохон кастодиан банк дотоодын хөрөнгийн зах зээл дээр Монголын банктай хамтарч ажиллахаар болов.

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


МХБ ТӨХК нь 2017 онд үйл ажиллагаанаас нийт **1.9 тэрбум** төгрөгийн орлогыг олж, 1.2 тэрбум төгрөгийн зардал гаргаснаар нийт **681.5 сая** төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба МIТ цогц системийн ашиглалт, хорогдолд нийт 909.7 сая төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайлангаа татварын өмнөх байгалаар **228.2 сая** төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөг байна.



# САНХУУГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2016 ОН

1,190.0  
сая төгрөг



2,055.8  
сая  
төгрөг

Алдагдал  
2,055.2  
сая  
төгрөг

1,189.5  
сая төгрөг

2017 ОН

1,918  
сая төгрөг



1,236.9  
сая  
төгрөг

909.7  
сая  
төгрөг

Алдагдал  
228.2  
сая төгрөг


Үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлтийг 2016 оны үзүүлэлттэй харьцуулвал, 2017 онд үйл ажиллагааны нийт орлогыг 61%-аар нэмэгдүүлж, зардлыг 40%-аар бууруулан хэмнэж ажилласнаар санхүүгийн тайланг алдагдлын дүнг өмнөх оноос 9 дахин бууруулж ажиллалаа.

Үйл  
ажиллагааны  
орлого

Үйл  
ажиллагааны  
зардал

MIT  
ашиглалтын  
зардал

# САНХУУГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




■ Үйл ажиллагааны нийт орлого

■ Арилжааны шимтгэлийн орлого

■ Хураамж, үйлчилгээний хөлс

■ Арилжарны шимтгэлийн орлого


# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



2017 оны Улсын төсвөөс 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч, "Ажлын мастер гэрээ"-ний гагуу өмнөх онуудын өр төлбөр болох 459,500 ам.долларын өглөгийг Лондонгийн хөрөнгийн бирж групп төлж барагдуулсан ба түүнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар болох 112.4 сая төгрөгийг Улсын төсөвт төлж, шилжүүлсэн болно.

# УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР

МХБ ТӨХК нь 2017 онд Улсын төсөвт нийт **418.1 сая** төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн.





**“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК**

*Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, Монгол Улс*

*Факс: (976)-11-325 170*

*Веб хуудас: [www.MSE.mn](http://www.MSE.mn)*